



**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 00-ны өдөр

Дугаар 8/18

Эрдэнэт

“Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай”

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын “Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвлүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төлөвлөгөө”, Нийгмийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 03 сарын 18-ны өдрийн 131 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай 400.000 /дөрвөн зуун мянга төгрөг/-ийг холбогдох эрх зүйн хүрээнд шийдвэрлэхийг Салбарын санхүү нягтлан бодох бүртгэлийн ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцон тайлagnаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ц.МОНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
02 дугаар сарын 20-ны өдрийн
A/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Гишүүд:

- Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл
сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг:

- Эрүүл мэндийн газрын зураглаач
- БОЭТ-ийн сүрьеэгийн кабинетийн диспансер
- Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн ажилтан
- Амьсгалын зам, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
23 дугаар сарын 16-ны өдрийн
118 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“СҮРҮЕЭТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЯНЫ УДИРДАМЖ

Орхон аймаг

2020.03.20

Үндэслэл: Жил бүрийн 03 сарын 24-ний өдрийг “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр болгон тэмдэглэдэг ба 2020 оныг “ЦАГ НЬ БОЛЛОО” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Монгол улсын хэмжээнд 2019 онд сүрьеэ өвчний 3624 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 8.0 хувийг эзэлж, 10 000 хүн амд ногдох өвчлөл нь 11.2 буюу өнгөрсөн оны мөн үеэс 126 тохиолдоор өссөн байна. Нийт өвчлөлийн 2109 тохиолдол буюу 58.2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Орхон аймагт 2019 онд сүрьеэ өвчний шинэ тохиолдол 77 илэрсэн ба сүрьеэгийн өвчлөл 10000 хүн амд 7 промилл буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 промиллоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зорилго: Сүрьеэгийн эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох

Зорилт:

1. Зорилтот бүлэгт сүрьеэгийн эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах
2. Хүн амын дунд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа мэдээлэл хийх
3. Сүрьеэ өвчтэй иргэдийг нийгмийн халамжийн асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх

Хугацаа: 2020оны 03 сарын 20-ний өдрөөс эхлэн 03сарын 31 өдрүүдэд

Хамрах хүрээ:

1. Сүрьеэгийн өдрийн эмчилгээний цэгээс эм ууж байгаа 48 иргэн, ДЗОУБ-ын хөтөлбөрт хамрагдаагүй үлдсэн хүүхдүүд
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хорих 437-р нээлттэй ангийн ажилтан албан хаагчид, хүмүүжигчид
3. Орон гэргүй тэнэмэл иргэд
4. ӨЭМТ-үүдэд үйлчлүүлж буй үйлчлүүлэгч наарт сүрьеэгийн мэдлэгэ олгох

Хамтран хэрэгжүүлэх байгууллага:

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
2. ЦАГДААГИЙН ГАЗАР
3. ДЭЛХИЙН ЗӨН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
4. БУСИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ
5. ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ
6. СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Хүлээгдэж буй үр дүн:

- Сүрьеэгийн өвчнөөс сэргийлэх чиглэлээр иргэдийн мэдлэг хандлага дээшилнэ.
- Зорилтот бүлгийг эрт илрүүлэг, үзлэгт хамруулснаар сүрьеэ өвчний оношилгоо, эмчилгээнд чанарын ахиц гарна.
- Сүрьеэгийн өдрийн эмчилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгч сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэгт хамрагдсан байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

№	Хөтөлбөр	Хугацаа	Хариуцах албан байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хүрэх үр дүн
1	Сүрьеэ өвчнөөс сэргийлэх цахим зөвлөмж нэвтрүүлэг хийх	03 сарын 20-31	НЭМТ	БОЭТ-ийн Сүрьеэгийн диспансер	Иргэдийн хандалт, сэтгэгдэл
2	ШШГ хорих 437 дугаар хорих ангийн албан хаагч, хүмүүжигчдэд сүрьеэ, БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэг, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	03 сарын 24	НЭМТ	БОЭТ ШШГ Хорих 437-р анги	- Илрүүлэг үзлэгийн дүгнэлт - Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамж
3	Орон гэргүй, тэнэмэл иргэдэд сүрьеэ, БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэг, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	03 сарын 25	НЭМТ	БОЭТ, Цагдаагийн газар	- Илрүүлэг үзлэгийн дүгнэлт - Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамж
4	Сүрьеэ өвчнөөс сэргийлэх чиглэлээр телевизийн нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд хүргэх	03 сарын 24	НЭМТ	БОЭТ	Нэвтрүүлэг бэлтгэгдэж иргэдэд хүрсэн
5	Сүрьеэтэй эмчлүүлэгчдийг амин дэмжүүлэх	03 сарын 24	НЭМТ	БОЭТ	Амин дэмжүүлсэн иргэдийн тоо
6	ЭМБ-уудад сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж, уриалга байршуулж хуанли, гарын авлага түгээх сурталчилах	03 сарын 23-27	НЭМТ	ЭМБ-ууд	Байрлуулсан зурагт хуудас, уриалгын тоо
7	Сүрьеэтэй 5 өвчтөнд хүнсний буцалтгүй тусламж үзүүлэх, сүрьеэтэй иргэдийн хүүхдийг хalamжийн хөтөлбөрт хамруулах	03 сарын 24	НЭМТ	ДЗОУБ	Хүнсний буцалтгүй тусламж авсан иргэдийн тоо

8	Сүрьеэтэй өвчтөнд хүнсний буцалтгүй тусламж үзүүлэх	03 сарын 24	НЭМТ	Халамж үйлчилгээн ий газар	Хамрагдсан иргэдийн тоо
9	“Сүрьеэгүй ирээдүйд залуучууд бидний оролцоо” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулах	03 сарын 20-03 сарын 31	НЭМТ	Иргэдийн дунд	Уралдааны дүн

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ХӨАСХМ

ХЯНАСАН: СТУХМ

Б.БИЛГҮҮНЭЭ

А.БАЯРХҮҮ

**ДЭЛХИЙН СҮРҮЕЭГИЙН ЭСРЭГ ӨДӨР' АЯНЫ ЗОХИОН ЯВУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ:**

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төг/
Бичиг хэргийн зардал					
1.	Шохойтой цаас	ш	50 / A4/	200₮	10.000₮
2.	Өнгөт хор	ш	6	2500₮	15.000₮
Нэмэлт амин дэмжүүлэлт					
3.	Ундевит	ш	48	3800₮	182.400₮
Шатахууны зардал					
4.	Бензин	л	15	1840₮	27.600₮
Уралдааны шагнал					
5.	1-р байр 50000₮ 2-р байр 30000₮ 3-р байр 20000₮	Төгрөг			100.000₮
Орон гэргүй тэнэмэл иргэдэд зарцуулах зардлын тооцоо					
6	Mack	ш	65	1000₮	65000₮
Нийт дүн					
400.000₮					

ТӨСӨВ ГАРГАСАН: ЭМЭЗТТЗХМ

Д.ОТГОНДЭЛГЭР

ХЯНАСАН: ССБМНБА

Н.ЧУЛУУНЭРДЭНЭ